



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И мэйл: ub@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn

2023.03.15 № 628
танай _____-ны № _____-т

“БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН
НЭГЖ” УТУГ-ЫН ДАРГА Н.УУГАНБАЯР ТАНАА

“Бэлчээрийн менежмент төслийн нэгж”
УТУГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, санал
дүгнэлтийг хүргүүлж байна.

Хавсрал ²⁴ . . . хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2023.03.160



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И мэйл: ub@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn

2023.03.15 № 629
танай _____ -ны № _____ -т

**“БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ
ТӨСЛИЙН НЭГЖ” УТҮГ-ЫН
ДАРГА Н.УУГАНБАЯР ТАНАА**

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” УТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Бэлчээрийн менежмент төслийн нэгж” УТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллагын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 2016 оны 02 сарын 17-ны өдрийн гэрчилгээнд байгууллагын хариуцлагын хэлбэрийг “төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар” гэж бүртгэсэн байгаа ба байгууллагын тамга тэмдэг нь “УТҮГ” гэсэн байна.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 7 сарын 3-ны өдрийн Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ байгуулах тухай 121-р тогтоолоор баталсан дүрэмд “ОНӨТҮГ” байхаар тусгасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудлыг тодорхойлоход материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн үнэлгээ өндөр, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын шийдвэр гаргасан чухал

асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 7 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100.0 хувийн биелэлттэй гэж төслийн удирдлага үзсэн байна. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг болон Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны харьяа орон нутгийн өмчит төсөвт болон аж ахуйн тооцоот байгууллагуудын 2022 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэх ажлын хэсгийн шалгалт явагдаж байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

М.ЭРДЭНЭЖАРГАЛ

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Бэлчээрийн менежмент төслийн нэгж”-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2023/49/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2023 он

“Нийслэл аудит” ХХК-ийн захирал: Т.Сугарсүрэн
Утас: 99115395 Цахим хаяг: : info@niislelaudit.mn

Чанарын хяналтын менежер: Г.Жаргал
Утас: 99105629 Цахим хаяг: g.jargal@niislelaudit.mn

Ахлах аудитор: Л.Ганзориг
Утас: 91918416 Цахим хаяг: g.lkhagvajav@niislelaudit.mn
Аудитор: Б.Батаа
Утас: 88881365 Цахим хаяг: undefined:bataabct@gmail.com
Аудитыг гүйцэтгэсэн: “Нийслэл аудит” ХХК
Утас: 976-11-318918 Цахим хаяг: info@niislelaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	0
4.1 Ерөнхий зүйл	7
4.2 Материаллаг байдал	7
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	8
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	8
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	8
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	9
4.5.1 Завсрын аудитын талаар	9
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	9
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
5.3 Зөвлөмж	10
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	11

Товчилсон үгийн жагсаалт

НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон улсын стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон улсын стандарт
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	110,232,066.73	111,663,367.56
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
3121	Төгрөг	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	110,232,066.73	111,663,367.56
351	Түүхий эд материал	1,058,700.00	3,128,950.00
35110	Тусгай зориулалттай материал	1,026,700.00	2,981,950.00
35130	Эм боох материал	32,000.00	147,000.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	15,369,773.73	12,707,979.56
354	Хангамжийн материал	42,661,093.00	38,279,350.00
35410	Бичиг хэргийн материал	622,440.00	484,440.00
35420	Аж ахуйн материал	5,352,799.00	2,317,800.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,910,000.00	1,910,000.00
35470	Бусад хангамжийн материал	34,775,854.00	33,567,110.00
35600	Мал, амьтад	51,142,500.00	57,547,088.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,729,319,733.99	1,593,964,837.46
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,729,319,733.99	1,593,964,837.46
392	Биет хөрөнгө	1,727,202,067.13	1,592,722,670.56
39201	Барилга, байгууламж	849,953,358.00	909,854,256.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(12,750,545.78)	(52,279,389.17)
39203	Авто тээврийн хэрэгсэл	563,363,658.00	563,363,658.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(269,014,325.20)	(325,565,691.24)
39205	Машин, тоног төхөөрөмж	627,438,763.96	627,438,763.96
39206	Хуримтлагдсан элэгдэл	(276,895,666.22)	(339,765,495.33)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,371,897.00	29,371,897.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(21,895,673.85)	(25,039,253.85)
39214	Бусад үндсэн хөрөнгө	321,197,562.40	321,197,562.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	(83,566,961.18)	(115,853,637.21)
393	Биет бус хөрөнгө	2,117,666.86	1,242,166.90
39301	Програм хангамж	1,020,000.00	1,020,000.00
39302	Хасагдуулга	(1,020,000.00)	(1,020,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	4,955,000.00	4,955,000.00
39304	Хасагдуулга	(2,837,333.14)	(3,712,833.10)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,839,551,800.72	1,705,628,205.02
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,839,551,800.72	1,705,628,205.02
215	Засгийн газрын хувь оролцоо	1,839,551,800.72	1,705,628,205.02
223	Хуримтлагдсан үр дүн	1,839,551,800.72	1,705,628,205.02
224	Өмнөх үеийн үр дүн	972,008,545.28	1,839,551,800.72
225	Тайлант үеийн үр дүн	867,543,255.44	(138,923,595.70)
231	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,839,551,800.72	1,705,628,205.02

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,290,732,494.00	383,549,933.09
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,026,909,694.00	68,333,133.09
120	Нийтлэг татварын бус орлого	1,026,909,694.00	68,333,133.09
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,026,909,694.00	68,333,133.09
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,640,000.00	26,103,000.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	1,023,269,694.00	42,230,133.09
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	263,822,800.00	315,216,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,860,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,860,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	258,962,800.00	315,216,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	258,962,800.00	315,216,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	423,189,238.56	517,473,528.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	423,189,238.56	517,473,528.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	417,011,379.46	494,565,193.95
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	136,584,697.07	152,251,231.94
210101	Цалин	86,553,693.12	102,061,969.94
210102	Нэмэгдэл цалин	37,931,003.95	38,089,262.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,100,000.00	12,100,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,398,755.21	19,510,204.68
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	12,918,565.21	13,061,054.76
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,382,648.00	1,881,612.48
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,092,677.00	1,218,010.18
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	273,170.00	304,502.30
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	2,731,695.00	3,045,024.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,034,756.64	44,098,249.91
210301	Гэрэл цахилгааны зардал	6,913,556.64	4,563,049.91
210302	Түлш, халаалтын зардал	2,250,000.00	2,664,000.00
210303	Цэвэр, бохир усны зардал	4,200,000.00	4,200,000.00
210304	Байрны түрээс	32,671,200.00	32,671,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,022,068.98	32,769,510.63
210401	Бичиг хэргийн материал	1,034,400.00	835,500.00
210402	Тээвэр, шатахууны зардал	13,900,065.60	21,857,590.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	1,960,103.38	2,058,060.63
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	1,750,000.00	989,300.00

210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	5,757,500.00	1,533,860.00
210408	Бараа материал актасны зардал	3,620,000.00	5,495,200.00
2105	Нормативт зардал	-	2,112,400.00
210501	Эм	-	1,392,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	720,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	5,314,899.00
210601	Багаж хэрэгсэл	-	3,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	-	2,314,899.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	11,950,068.00	14,400,068.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,505,000.00	94,500.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	6,000,000.00	6,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	216,000.00	6,460,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	245,300.00	254,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	99,000.00	110,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	1,860,000.00	1,456,000.00
210807	Газрын төлбөр	24,768.00	24,768.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	176,021,033.56	224,108,629.79
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,520,920.00	46,523,600.17
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	163,500,113.56	177,585,029.62
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,177,859.10	21,505,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	21,005,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	21,005,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	2,000,000.00	500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,177,859.10	1,402,834.84
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,177,859.10	1,402,834.84
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	867,543,255.44	(133,923,595.70)
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	867,543,255.44	(133,923,595.70)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	0.00	0.00	986,688,545.28	986,688,545.28
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(14,680,000.00)	(14,680,000.00)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	972,008,545.28	972,008,545.28
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	-	-	-
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0.00	0.00	867,543,255.44	867,543,255.44
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	0.00	0.00	1,839,551,800.72	1,839,551,800.72
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,839,551,800.72	1,839,551,800.72
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0.00	0.00	(133,923,595.70)	(133,923,595.70)
2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	0.00	0.00	1,705,628,205.02	1,705,628,205.02

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	265,616,900.00	329,489,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,794,100.00	14,273,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,794,100.00	14,273,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,794,100.00	14,273,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,794,100.00	14,273,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	263,822,800.00	315,216,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,860,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,860,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	258,962,800.00	315,216,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	258,962,800.00	315,216,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	259,621,900.00	329,489,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	259,621,900.00	329,489,800.00
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	253,444,040.90	306,581,465.16
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	136,584,697.07	152,251,231.40
210101	Үндсэн цалин	86,553,693.12	102,061,969.40
210102	Нэмэгдэл	37,931,003.95	37,931,003.95
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,100,000.00	38,089,262.00
210104	Үр дүнгийн урамшуулал	-	12,100,000.00
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	18,398,755.21	19,510,205.22
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	13,045,181.49	13,216,754.81
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,342,930.16	1,554,912.33
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,094,900.00	952,000.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	271,400.00	552,513.42
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	2,644,343.56	3,234,024.66
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	46,034,756.64	44,098,249.91
210301	Гэрэл цахилгааны зардал	6,913,556.64	4,563,049.91
210302	Түлш, халаалтын зардал	2,250,000.00	2,664,000.00
210303	Цэвэр, бохир усны зардал	4,200,000.00	4,200,000.00
210304	Байрны түрээс	32,671,200.00	32,671,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,759,613.98	33,938,910.63
210401	Бичиг хэрэг	1,000,000.00	783,500.00
210402	Тээвэр, шатахуун	20,049,510.60	24,807,590.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,960,103.38	2,058,060.63
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,750,000.00	1,320,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	4,969,760.00

2105	Нормативт зардал	-	2,220,000.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	1,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	720,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	5,000,000.00
210601	Багаж техник хэрэгсэл	-	3,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл	-	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,950,068.00	14,444,068.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	3,505,000.00	94,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,000,000.00	6,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	216,000.00	6,460,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	245,300.00	254,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	110,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,860,000.00	1,500,000.00
210807	Газрын төлбөр	24,768.00	24,768.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,716,150.00	35,118,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,716,150.00	35,118,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,177,859.10	22,908,334.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	21,505,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		21,505,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	2,000,000.00	500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,177,859.10	1,402,834.84
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,177,859.10	1,402,834.84
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	5,995,000.00	-
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	5,995,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,995,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	5,995,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,995,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(5,995,000.00)	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
305	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

№	Үзүүлэлт	2022 оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	(0.00)	0.00
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	329,486,800.00	328,086,965.16	1,399,834.84	99.58
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	329,486,800.00	328,086,965.16	1,399,834.84	99.58
210	Бараа, үйлчилгээний зардал	307,981,300.00	306,581,465.16	1,399,834.84	99.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	152,346,700.00	152,251,231.40	95,468.60	99.94
210101	Үндсэн цалин	102,157,400.00	102,061,969.40	95,430.60	99.91
210102	Нэмэгдэл	38,089,300.00	38,089,262.00	38.00	100.00
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	12,100,000.00	12,100,000.00	-	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,264,400.00	19,510,205.22	754,194.78	96.28
210201	Тэтгэврийн даатгал	13,496,900.00	13,216,754.81	280,145.19	97.92
210202	Тэтгэмжийн даатгал	1,691,900.00	1,554,912.33	136,987.67	91.90
210203	ҮОМШӨ ний даатгал	1,353,500.00	952,000.00	401,500.00	70.34
210204	Ажилгүйдлийн даатгал	338,400.00	552,513.42	(214,113.42)	163.27
210205	Эрүүл мэндийн даатгал	3,383,700.00	3,234,024.66	149,675.34	95.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,470,100.00	44,098,249.91	371,850.09	99.16
210301	Гэрэл цахилгаан	4,934,900.00	4,563,049.91	371,850.09	92.46
210302	Түлш, халаалт	2,664,000.00	2,664,000.00	-	100.00
210303	Цэвэр, бохир ус	4,200,000.00	4,200,000.00	-	100.00
210304	Байрны түрээс	32,671,200.00	32,671,200.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,962,000.00	33,938,910.63	23,089.37	99.93
210401	Бичиг хэрэг	500,000.00	783,500.00	(283,500.00)	156.70
210402	Тээвэр (шатахуун)	24,880,000.00	24,807,590.00	72,410.00	99.71
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	2,292,000.00	2,058,060.63	233,939.37	89.79
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,320,000.00	1,320,000.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	4,970,000.00	4,969,760.00	240.00	100.00
2105	Нормативт зардал	2,220,000.00	2,220,000.00	-	100.00
210501	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	1,500,000.00	1,500,000.00	-	100.00
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	720,000.00	720,000.00	-	100.00
2106	Эд хогшил худалдан авах	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,000,000.00	3,000,000.00	-	100.00
210602	Тавилга	-	-	-	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	-	-	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	14,598,100.00	14,444,068.00	154,032.00	98.94
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	94,500.00	94,500.00	-	100.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	6,000,000.00	6,000,000.00	-	100.00

“Бэлчээрийн менежмент төслийн нэгж” УТУГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

210803	Даатгалын үйлчилгээ	6,467,600.00	6,460,000.00	7,600.00	99.88
210804	Тээврийн хэрэгслийн татвар	295,500.00	254,800.00	40,700.00	86.23
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	160,500.00	110,000.00	50,500.00	68.54
210806	Мэдээллийн технологийн зардал	1,500,000.00	1,500,000.00	-	100.00
210807	Газрын төлбөр	80,000.00	24,768.00	55,232.00	30.96
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	35,120,000.00	35,118,800.00	1,200.00	100.00
21	Бараа үйлчилгээний бусад зардал	35,120,000.00	35,118,800.00	1,200.00	100.00
2132	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	-	-	-
213209	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,505,500.00	21,505,500.00	-	100.00
	Бусад урсгал шилжүүлэг	21,505,500.00	21,505,500.00	-	100.00
1310	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	-	-	-
131001	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,005,500.00	21,005,500.00	-	100.00
32	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	500,000.00	500,000.00	-	100.00
320001	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	329,486,800.00	328,086,965.16	1,399,834.84	99.58
35	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	315,216,800.00	313,813,965.16	1,402,834.84	99.55
350001	Орон нутгийн төсвөөс	315,216,800.00	313,813,965.16	1,402,834.84	99.55
350003	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	14,270,000.00	14,273,000.00	(3,000.00)	100.02
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
5	Үндсан үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,270,000.00	14,273,000.00	(3,000.00)	(3,000.00)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	(0.00)	0.00	0.00
5	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		-	-	-
5	БАЙГУУЛЛАГЫН ТОО		-	-	-
5	АЖИЛЛАГСДЫН ТОО		10.00	10.00	-
5	Удирдах ажилтан		1.00	1.00	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” УТҮГ, түүний үйл ажиллагаа

ОНӨТҮГ-ын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Бэлчээрийн менежмент төслийн зорилго нь Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Австри улсын дэвшилтэт технологийн дагуу бэлчээрийн талбайн хөрсний бүтцийг алдагдуулахгүйгээр өөрийн орны хөрс, цаг уурын нөхцөлд тохируулан, байгаль орчинд ээлтэй, олон наст ногоон тэжээлийг тарималжуулан нутагшуулах замаар тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бэлчээр ашиглалтыг сайжруулах, тэжээлийн олон наст ургамлыг тарьж, чанар сайтай хадлан, тэжээл авахад оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Австри улсын дэвшилтэт технологийн дагуу бэлчээрийн талбайн хөрсний бүтцийг алдагдуулахгүйгээр өөрийн орны хөрс, цаг уурын нөхцөлд тохируулан, байгаль орчинд ээлтэй, олон наст ногоон тэжээлийг тарималжуулан нутагшуулах замаар тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бэлчээр ашиглалтыг сайжруулах гэж тодорхойлжээ.

Нэгжийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- Бэлчээрийн талбайг хагалахгүй, хөрсний унаган төрхийг алдагдуулахгүйгээр үрлэж тариалах шинэ технологийг нэвтрүүлснээр бэлчээрийн талхагдлыг багасгаж, цөлжилтийг бууруулна.
- Тэжээлийн ургамлын зүйлийн бүрэлдэхүүнийг нэмэгдүүлэх замаар нэгж талбайгаас авах хадлангийн гарцыг 2-3 дахин ихэсгэх боломж бүрдэнэ.
- Дээрх шинэ технологийн дагуу тариалсан олон найрлагат, уурагжуулсан витаминт тэжээлийг вакуумжуулан боох аргыг үйлдвэрлэлд нэвтрүүлснээр өвөл, хаврын улиралд 4 шимт чанарыг алдагдуулахгүйгээр малаа тэжээх боломж бүрдэнэ.
- Туршилтын талбай, тэжээл, сүүний гарцын судалгаа болон сургалт, засварын төв бүхий “Эрчимжсэн мал аж ахуйн загвар аж ахуй” байгуулна.
- Малчид, фермерүүдийн дундын хоршоо байгуулах ба ингэснээр төслийн хүрээнд хийх “Эрчимжсэн мал аж ахуйн загвар аж ахуй”-нд тулгуурлан практик байдлаар дээрх дэвшилтэт технологиудыг танилцуулах, сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх, хамтран ажиллах, бодитоор хэрэгжүүлэхэд нь туслах юм.
- Нэг монгол үнээнээс саалийн хугацаанд авах сүүний гарц 2000 л байдаг бол нэгж талбайгаас авах ногоон массын ургац болон тэжээлийн шимт чанарыг сайжруулснаар сүүний гарцыг 2 дахин нэмэгдүүлнэ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Улсын Төсөвт Үйлдвэрийн Газар гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар эзэмшиж байна.

3.2 “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” УТҮГ-ын гадаад, дотоод орчин

ОНӨТҮГ-ын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Бэлчээрийн менежмент төслийн нэгж УТҮГ нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 121 дүгээр тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;” гэсэн заалттай нийцэж байна.

НЗД-ын 2017 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн А/282 тоот захирамжаар тус газрын бүтэц, орон тоог шинэчлэн 10 хүний орон тоотойгоор баталж, үйл ажиллагааг явуулж байна. Дахин өөрчлөлт ороогүй байна.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын дүрэмд тусгагдсаны дагуу тус нэгж нь үндсэн болон санхүүгийн үйл ажиллагааг хянах дотоод хяналттай байна. Дотоод хяналт шалгалтын ажиллах журмыг захирал батална гэж тусгасан ч одоогоор дотоод бүтэц зохион байгуулалтад энэ нь биеллээ олоогүй байна.

Дотоод хяналтыг Нийслэлийн Дотоод хяналтын алба хэрэгжүүлж байгаа. Тайлант онд 2020 он, 2021 он, 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 2022 оны 9 сарын 16-ны өдрийн 1/166 тоот албан бичгээр дотоод аудитын тайланг хүргүүлсэн байна. Уг тайланд нийт 8 зөвлөмж өгч, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах үүрэг даалгавар өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж УТҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Бэлчээрийн менежмент төслийн нэгж” УТҮГ-ын 2022 санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой байгууллагын ерөнхий үйл ажиллагааны хүрээнд нийцэх ч үндсэн чиглэл болох биологийн хөрөнгө хүлээн зөвшөөрөлт, түүний өсөлт бууралт, хэмжилтийг хэрхэн бүртгэхтэй холбоотой тусгай бодлого бүрэн тусгагдаагүй байгаа нь өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогоо сайжруулан шинэчлэх шаардлагатай байна. Шинэчлэл хийхгүйгээс биологийн хөрөнгөтэй холбоотой буруу журнал бичилтүүд гарч байна.

НБББББ (2018.12.31-нд батлан мөрдөж буй) нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой байгууллагын ерөнхий үйл ажиллагааны хүрээнд нийцэх ч үндсэн чиглэл болох биологийн хөрөнгө хүлээн зөвшөөрөлт, түүний өсөлт бууралт, хэмжилтийг хэрхэн бүртгэхтэй холбоотой тусгай бодлого бүрэн тусгагдаагүй байгаа нь өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогоо сайжруулан шинэчлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн “Acolous” программ, цалингийн Пэйрол систем ашигладаг. Сул тал нь үйлдвэрлэлийн өртөг, зардлын бүртгэлтэй холбоотой журнал бичилтүүдийг хийх боломжгүй, үйлдвэрлэл хоорондын хөдөлгөөнийг стандарт бус бичилтээр хийгдэг. Шинэчлэлт тогтмол хийгддэггүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Бэлчээрийн менежмент төслийн нэгж УТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 133,923.6 мянган төгрөгөөр буюу 7.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	110,232.07	111,663.37	1,431.30
Үндсэн хөрөнгө	1,729,319.73	1,593,964.84	(135,354.89)
Нийт хөрөнгө	1,839,551.80	1,705,628.21	(133,923.59)
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,839,551.80	1,705,628.21	(133,923.59)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,839,551.80	1,705,628.21	(133,923.59)

Бараа материалын дансны үлдэгдэл 111,663.4 мянган төгрөг болж өссөн байна. Үүнд; Мал амьтад оны эхэнд 51,142.5 мянган төгрөг байсан ба 101,651.7 мянган төгрөгийн мал амьтад худалдан авах болон шилжүүлж авсан, 95,247.1 мянган төгрөгийн мал амьтад худалдсан болон устгалд оруулж, нийт 57,547.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь нийт бараа материалын 56.6 хувийг эзэлж байна. Үлдсэн 43.4 хувь нь түүхий эд материал 2,981.9 мянган төгрөг, дуусаагүй үйлдвэрлэл 12,708.0 мянган төгрөг, аж ахуйн материал 2,317.8 мянган төгрөг, сэлбэг хэрэгсэл 1,910.0 мянган төгрөг, бусад хангамжийн материал 33,567.1 мянган төгрөг, бичиг хэргийн материал 484.4 мянган төгрөг, эм боох материал 147.0 мянган төгрөг буюу 111,663.4 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны өөрчлөлт дараах шалтгаантай байна. Үүнд:

Төсвийн хөрөнгөөр 59,900.0 мянган төгрөгийн худалдан авалт хийж Бусад үндсэн хөрөнгө дансанд, Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогод Нийслэлийн засаг даргын тамгын газрын 2022 оны 12 сарын 26-ний өдрийн 2/1720 дугаар захирамж, Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын 2022 оны 12 сарын 16-ны өдрийн А/765 дугаартай албан тоотыг тус тус үндэслэн байгууллагын даргын 2022 оны 12 сарын 21-ний өдрийн А/14 тоот шийдвэрээр нийт 59,900.0 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авч холбогдох дансанд бүртгэсэн байна.

Бэлчээрийн менежмент төслийн нэгжийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны орлого өмнөх оноос (907,182.6) мянган төгрөгөөр буюу 336.5 хувиар буурсан байна. Үүнийг ангилж харуулбал;

- *Татварын бус орлого (958,576.6) мянган төгрөгөөр буурсан (үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө (981,039.6) мянган төгрөгөөр*

буурч, үндсэн үйл ажиллагааны орлого 22,463.0 мянган төгрөгөөр өссөн) байна.

- Тусламж санхүүжилтийн орлого 51,394.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Зардал өмнөх онтой харьцуулахад зардал 94,284.3 мянган төгрөгөөр өссөн нь цалингийн зардал болон бараа үйлчилгээний бусад зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Бэлчээрийн менежмент төслийн нэгж УТҮГ-ын тайлант онд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилго: 3.3. “Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос хангана” гэсэн зорилгын хүрээнд:

Зорилт1.

Хөдөө аж ахуйн зориулалттай газрын ашиглалтыг сайжруулж, өрхийн тариаланг нэмэгдүүлэн, хөрс, цаг уурын онцлогт тохирсон таримлыг тариалуулж, бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлнэ.

Авсан арга хэмжээ:

- Туршилтын талбайг бууц, органик бордоогоор бордож хөрсний чанарыг сайжруулах
- Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагддаг бүх техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, урсгал засварыг цаг тухайд нь хийж, байнгын бэлэн байдлыг хангаж ажиллах
- Байгууллагын техник, тоног төхөөрөмжүүдийг ашиглан иргэд, аж ахуйн нэгжүүдийн захиалгын дагуу газар тариалангийн үйлчилгээг гэрээний дагуу гүйцэтгэх.
- Туршилтын талбайгаас хадлан тэжээл хураан авах, пресслэх, ногоон тэжээл бэлтгэх, зориулалтын газарт хурааж, хадгалах

Гүйцэтгэл:

- ✓ Туршилтын 150 га талбайгаас 2022 оны 05 дугаар сарын эхний 5 хоногт хөрсний үржил шимийн үзүүлэлт, тариалалт хийсэн олон наст ургамлын ургалтын байдлыг харгалзан 10 га талбайг сонгон авч 1 га-д 10 тн нормоор тооцож компост бордоо болон бууцаар бордох ажлыг хийсэн. Дараа жил туршилтын талбайг нэмж бордоход зориулж, фермийн ойролцоох малчин өрхүүд болон өөрсдийн үнээ, малаас гарсан өтөг бууцыг цуглуулж 50 тонн органик бордоо бэлдсэн.
- ✓ Урсгал засварын төлөвлөгөө боловсруулан, батлуулж, төлөвлөгөөт хугацаанд тракторын турбин болон гидрийн механизмын гэмтлийг оношлон, засварын ажлыг амжилттай гүйцэтгэсэн. Мөн хөрс боловсруулах, үрлэгээ

хийх болон намрын ургац хураалтын ажилд ашиглах бүх тоног төхөөрөмжийн урсгал засварын ажлыг гүйцэтгэсэн.

- ✓ Сонгинохайрхан дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг нэг аж ахуйн нэгж, 4 иргэний захиалгын дагуу “Газар тариалангийн үйлчилгээ үзүүлэх гэрээ” байгуулан газар хагалах, хөрс боловсруулах, өвс хадлан хураан авах ажлыг хавар, намрын улиралд хийж гүйцэтгэсэн. Нэмж 1 байгууллага, 3 иргэний хүсэлтээр дээрх төрлийн үйлчилгээг үзүүлж ажилласан.
- ✓ Туршилтын талбай болон ногооны 5 га талбайгаас нийтдээ 116 боодол буюу 38 тонн хуйлсан ногоон тэжээл хураан авсан.

Зорилт2.

Сургалтын төв, дадлагын талбай болон засварын төв бүхий “Эрчимжсэн мал аж ахуйн загвар аж ахуй байгуулах”

Авсан арга хэмжээ:

- Эрчимжсэн мал аж ахуйн фермийн байнгын үйл ажиллагааг хангаж ажиллах, өдөр тутмын ажлыг графикийн дагуу гүйцэтгэх, малыг эрүүл мэндийн үзлэг болон урьдчилан сэргийлэх тарилга, вакцинжуулалтад байнга хамруулах,
- Нийслэлийн иргэд, малчид, фермерүүдэд зориулж малчдын хоршоо байгуулах, түүний ач холбогдол болон хөдөө аж ахуйн чиглэлээр сургалт зохион байгуулах

Гүйцэтгэл:

- ✓ Энэ онд 20 үнээ тугалж, 20 төл хүлээн авсан. Фермийн байнгын үйл ажиллагааг ханган ажиллаж, гэрээт малын эмчид үзүүлэн, эрүүл мэндийн үзлэг болон вакцинжуулалтад бүрэн хамруулж ажиллаж байна. Тайлангийн хугацаанд нийт 7.5 тонн сүүг бэлтгэн нийлүүлсэн.
- ✓ Малын удмын сан, НХХААГ, “Нутаг академи” ТББ-тай хамтран “Бод малын зохиомол хээлтүүлгийн техникч бэлтгэх” сертификаттай сургалтыг байгууллагын 90 үхрийн аж ахуй дээр зохион байгуулсан. Хөдөө орон нутаг болон нийслэлээс тус сургалтанд хамрагдсан 27 хүнд байгууллагын зүгээс нэвтрүүлж байгаа дэвшилтэт техник, технологийн талаар болон малын өтөг бууц, хүнсний био хог хаягдлыг ашиглан компост бордоо хийж бэлчээр, хадлангийн талбайг бордож, хөрсний үржил шимийг сайжруулж байгаа үр дүнг танилцуулж, зөвлөгөө өгсөн.
Фермер Г.Туул тус сургалтанд амжилттай хамрагдан сертификат гардан авсан.
Мөн ойр хавийн малчин фермер өрхүүдийн төлөөлөл 25 иргэнд бууцыг бордоонд ашиглах, хошуу будаа, арвай, улаан буудай, вандуй гэх нэг наст ургамлуудыг дангаар нь болон хольж тариалан ногоон тэжээл хэрхэн бэлтгэх талаар сургалт зөвлөгөө өгч ажилласан.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилго: 4.1. “Мэдээлэл технологийн ухаалаг

шийдлүүдийг ашиглан хотын цогц үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, нээлттэй, чирэгдэлгүй хүргэдэг ухаалаг хотыг бий бологох” гэсэн зорилгын хүрээнд:

Зорилт3.

Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангах

Авсан арга хэмжээ:

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтэд хяналт тавьж төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангуулна.
- “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд айл өрх, ААНБ-ыг идэвхтитэй оролцуулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлж, арчлалт хамгаалалтын менежментийн ажлыг сайжруулах

Гүйцэтгэл:

- ✓ Шилэн дансанд өссөн дүнгээр нийт 136 мэдээг хугацаанд нь тайлагнасан байна.
- ✓ “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон хот-Иргэний оролцоо” хаврын мод тарих аяны хүрээнд байгууллагын албан хаагчид 2022 оны 05 дугаар сарын 14-ний өдөр Хан-Уул дүүргийн 14 хороо, Айдсын ам /7 га/-ны талбайн хуваарьт газраа 24 ш хайлаас мод тариалав.
Үйл ажиллагаанд оролцохдоо Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт ногоон байгууламжийн гүйцэтгэл хяналтын хэлтэсээс зөвлөмж авч хамтран ажилласан.
Мөн Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны захиалгаар модны тарьц суулгац бэлдэх мод үржүүлгийн газар байгуулах ажлын хүрээнд Хужирбуланд 5 га атаршсан талбайг хагалж, хөрс боловсруулах ажлыг хийж гүйцэтгэв.
Фермийн хашаан дахь мод бут ногоон байгууламжийн арчилгаа усалгаа болон тохижилт, цэвэрлэгээний ажлыг тухай бүрд нь гүйцэтгэж ажилласан.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тус нэгжийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 329,486.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 329,486.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж, батлуулсан байна.

Тайлант онд төслийн нэгжийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 329,486.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 315,216.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 14,270.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 313,814.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоор 14,273.0 мянган төгрөг, нийт 328,087.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 327,087.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 328,087.0 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байна. Энэ нь ажиллагсадтай холбоотой зардлыг 849.7 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 371.9 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 23.1 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 154.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал зардлыг 1.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бэлчээрийн менежмент төслийн нэгж УТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Нийслэл-Аудит” ХХК-ийн аудитор Б.Батаа, аудитын туслах Д.Ариунцэцэг нар гүйцэтгэж, хяналтыг “Нийслэл-Аудит” ХХК-ийн чанарын хяналтын менежер Л.Сарантуяа, НТАГ-ын аудитын менежер Я.Алтанцэцэг, хэлтсийн дарга, аудитын менежер З.Мөнхбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Бэлчээрийн менежмент төслийн нэгжийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Нийслэл-Аудит” ХХК-д 2022 оны 02 дүгээр сарын 10-ны өдрийн Б/12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтийг нийт зардлаар 423,189.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,347.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 4,760.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна. Энэ хуулийн хүрээнд дэд дарга, орлогчийн орон тоо байхгүй.

Төрийн хэмнэлтийн хуулийн хүрээнд хэмнэсэн зардлууд:

- Сургалтын төвийн 2 давхар байраа өвлийн саруудад халаалтаа зогсоож хотын төвийн байрандаа сургалтаа хийж түлш, халаалтын зардлыг,

- Фермийн цахилгаан халаагуурыг өдрийн цагаар амрааж шөнийн хөнгөлөлттэй тарифын үеэр ажиллуулж гэрэл цахилгааны зардлыг

- Нийслэлийн төр захиргааны авто баазаас байгууллагын үйл ажиллагаанд зориулан түрээсэлдэг авто машины зорчих хөдөлгөөндөө хязгаарлалт хийж авто машины түрээсийн зардлыг тус тус хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 150 мэдээллээс 150 мэдээллийг хугацаанд нь оруулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу 7 удаагийн худалдан авалт зохион байгуулжээ.Үүнд: байрны түрээс, шатахууны төлбөр, авто машины түрээс, байрны төлбөр, гэрэл цахилгааны төлбөр, бусад бараа материалын төлбөр зэрэгт 90,324.9

мянган төгрөгийн худалдан авалтын төлөвлөгөө батлагдсанаас гүйцэтгэлээр 90,324.9 сая төгрөгийн худалдан авалт хийжээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар 5,533.5.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, зөрчлийг арилгах 2 зөвлөмж өгсөн. Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 16,090.6 мянган төгрөгийн 2 зөвлөмж, 1 албан шаардлага өгснөөс зөвлөмж жилийн эцсээр 93 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	1,994.2	1	1,994.2	100%
Зөвлөмж	2	14,096.4	2	14,096.4	80%
Нийт дүн	3	16,090.6	3	14,967.9	93%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

НБББББ болон ашиглаж буй программ хангамжийг шинэчлэн, өртгийн хувьд холбогдох дуусаагүй үйлдвэрлэлийн дансыг нээн бүртгэж буй эсэхийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,160.4 мянган төгрөгийн алдаа¹ зөрчил илэрснийг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар нийт 3,372.0 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд 1 зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Компанийн худалдан авалтыг тулган шалгахад 3,372.0 мянган төгрөгийн QR кодоор баталгаажуулсан и-баримтгүйгээр гүйлгээг хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягт нөхөх заавар”-ын 6.5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Мөнгөн хөрөнгийн зарлагын баримт болон бараа материалын худалдан авалтын баримтуудыг иж бүрэн бүрдүүлж, төлбөрийн и-баримтыг хавсаргаж байх;

2. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Дуусаагүй үйлдвэрлэл дансанд газар тариалан, мал аж ахуйтай холбоотой гарсан 2,160.4 мянган төгрөгийн шууд хөдөлмөр, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлыг тусгахгүйгээр үйл ажиллагааны зардлаар бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 дэх үнэн зөв байх гэсэн заалтыг зөрчсөн байна. Түүнчлэн УСНББОУС12 (Бараа материал)-ын 20 дугаар зүйл, НББОУС2 (Бараа материал)-ын 12 дугаар зүйлийн “Бараа материалын хувиргалтын зардал нь шууд хөдөлмөр гэх мэт бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шууд хамааралтай зардлуудаас бүрддэг... мөн материалыг бүтээгдэхүүн болгон хувиргахад гардаг үйлдвэрлэлийн тогтмол ба хувьсах нэмэгдэл зардлын системчилсэн хуваарилалт нь энд хамаардаг” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын үйл ажиллагааны зардалд тусгасан дээрх гүйлгээг мал аж ахуйтай холбоотой гарсан малын тэжээлийг фермийн үхрийн нас дэвшилт, төл мал болон сүүний өртөг зэрэгт шингээх зорилгоор, холбогдох дуусаагүй үйлдвэрлэлийн дансанд хуримтлуулан, газар тариалан болон олон наст ургамал ургахтай холбоотой гарсан үр, бордооны зүйлсийг олон наст ургамал, ногоон тэжээл зэргийн

өртөгт шингээх зорилгоор холбогдох дуусаагүй үйлдвэрлэлийн дансанд тус тус хуримтлуулан бүртгэж байх;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллага болон аудитын хуулийн этгээдэд 2023 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дуусаагүй үйлдвэрлэл дансанд газар тариалан, мал аж ахуйтай холбоотой гарсан төгрөгийн шууд хөдөлмөр, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлыг тусгахгүйгээр үйл ажиллагааны зардлаар бүртгэсэн	1	2,160.4	1	2,160.4					1	2,160.4	1	2,160.4
Дүн	1	2,106.4	1	2,160.4					1	2,160.4	1	2,160.4

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
QR кодоор баталгаажуулсан и-баримтгүйгээр гүйлгээг хийсэн.	1	3,372.6					1	3,372.6				
Дүн	1	3,372.6					1	3,372.6				

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

"НИЙСЛЭЛ АУДИТ" ХХК-ИЙН

АУДИТОР

B. Batana

Б.БАТАА

ХЯНАСАН:

"НИЙСЛЭЛ АУДИТ" ХХК-ИЙН

ЗАХИРАЛ **НИЙСЛЭЛ АУДИТ**
ХХК

T. Sugarsuren

Т.СУГАРСҮРЭН

НТАГ-2023/49/НА-СТА-ОНА

